



БНМАУ

УЛААНБААТАР ХОТЫН АРДЫН ДЕПУТАТУУДЫН
ХУРЛЫН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРГААНЫ

ТОГТООЛ

1990 оны 4 —
сарын 19 — өдөр

дугаар 60 .

Улаанбаатар

Хот
ХЗДХН 1993 оны А/262-р гишүүдийн хурлын

Тооцоолох төв байгуулах
тухай

БНМАУ-ын НААҮЯ татан буугцаж түүний харьяанд байсан зарим байгууллага Улаанбаатар хотын АДХ-ын гүйцэтгэх захиргааны мэдэлд илжин ирсэнтэй холбогдуулан хотын байгууллагуудын бүртгэл тооцооны ажлыг механикжуулах, автоматжуулах, удирдлагын автоматжуулсан цэд системүүдийн мэдээллийн сан бий болгох нэгдсэн бодлого явуулж, тооцоолох техник, нарийн мэргэжлийн боловсон хүчний хүчийг зөв зохистой хамтран ашиглах зорилгоор Улаанбаатар хотын АДХ-ын гүйцэтгэх захиргаанаас ТОГТООХ нь:

1. НААҮЯ-ны харьяанд байсан бүртгэлийн машинт станц, Улаанбаатар хотын АДХ-ын гүйцэтгэх захиргааны санхүү хэлтсийн мэдэлд байгаа тооцоолох техник, бусад тоног төхөөрөмжийг нэгтгэн Улаанбаатар хотын АДХ-ын гүйцэтгэх захиргаанд тооцоолох төв байгуулж аж ахуйн бүрэн тооцоон дээр ажиллуулсугай.

2. Тооцоолох төвийн сарын цалингийн сан, жишгийг 3 дугаар зэрэглэлийн тооцоолох төвд хамааруулан зохих журмын дагуу баталж өгөхийг Санхүүгийн хэлтэс /н.Тонгор/-т зөвшөөрсүгэй.

3. Тооцоолох төвд шаардагдах техник, сэлбэг хэрэгсэл, материалыг төлөвлөгөөнд тусгаж, хотын АДХ-ын гүйцэтгэх захиргааны тоног төхөөрөмжийн хөрөнгөөр олгож байхыг Төлөвлөгөө, эдийн засгийн хэлтэс /н.Бат/-т даалгасугай.

4. Тооцоолох төв байрлах ажлын байр, өрөө тасалгаа гаргаж өгөхийг хариуцлагатай нарийн бичгийн дарга н.Алгиад даалгасугай.

5. Тооцоолох төвөөр хийлгэх ажлын захиалгаа гаргаж хамтран ажиллахыг хотын АДХ-ын харьяа газар, хэлтэс, байгууллагын дарга, эрхлэгч нар, тооцоолох төвд үүрэг болгосугай.

6.Тооцоолох төвийн захирал /н.
цаалгах нь:

/-нд

а/хотын АДА-ын Тэргүүлэгчид, гүйцэтгэх захиргаа, харьяа байгууллагуудын анхан шатны бүртгэл, эдийн засаг, статистик, санхүүгийн тайлан мэдээг үе шаттайгаар механикжуулж автоматжуулах төлөвлөгөө график боловсруулан харагдуулах.

б/хотын удирдлагын автоматжуулсан дэд системийн мэдээллийн сая бий болгох ажлыг эдийн засгийн хэлтсүүд, харьяа газруудтай хамтран гүйцэтгэх.

в/хэлтэс газруудын ажилтан нэрт компьютерийн техникийг ашиглах талаар анхан шатны курс, дугуйлан зохион байгуулж, мэргэжлийн удирдлага, заавар аргачлалаар ханген ажиллаж байсугай.



УЛААНБААТАР ХОТЫН АДА-ЫН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРГААНЫ ДАРГА

[Signature]
Л.ЭНЭБИШ

ХАЗУУЛАГАТАЙ НАРИЙН
БИЧИЙН ДАРГА

[Signature]
Д.АЛГИА